



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 11 өдөр

Дугаар Аюу

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын газрын  
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан хоёр иргэн, аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан гурван иргэн аж ахуйн нэгжид дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Туушин зочид буудал ХХК "Туушин" зочид буудлын 13/153, АЭЭ трейдинг ХХК "Улз" дэн буудлын 13/269, Ундарга ХХК "Венус" зочид буудлын 16/172, Иргэн Ц.Солонго "Эндо" дэн буудлын 15/117, Иргэн М.Мөнх-Эрдэнэ "Секрет" дэн буудлын 15/053 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.
5. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Г.Цэрэннадмид/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 01 сарын 11  
өдрийн A/04 дүгээр тушаалын  
нэгдүгээр хавсралт

УОА0453

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.01.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Тушин зочид буудал ХХК	5434947	Бэст Вэстэрн Примьер Тушин	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий Сайд Амарын гудамж 15
2	Иргэн Б.Насанжаргал	ЧИ52122208	Венус	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, Их тойруу 4 а

-ооОо-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 01 сарын 11  
өдрийн A/04 дүгээр тушаалын  
хоёрдугаар хавсралт

УОА0453

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.01.11

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	АЗЭ трейдинг ХХК	2047241	Улз	Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Ата Туркийн гудамж 20/1
2	Иргэн Ц.Солонго	ЧС67101109	Эндо	Баянгол дүүрэг, 16-р хороо, Орхона 4/19
3	Иргэн М.Мөнх-Эрдэнэ	ЧС82082272	Секрет	Баянгол дүүрэг, 16-р хороо, Туулын 18/360

-ооОоо-